

СҮХБААТАР АЙМГИЙН БАРУУН-УРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ 2 ДУГААР САРЫН ТАЙЛАН

2022-02-23

Баруун-Урт

Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газрын зүгээс иргэдэд түргэн шуурхай, чанартай үйлчилгээг үзүүлэхийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

МАНАЙ БАЙГУУЛАГЫН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР ДАРААХ АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛЖ АЖИЛЛАСАН.

1. Тус Тамгын газарт ирсэн 64 бичиг / *Үүнээс-18 албан бичиг хугацаандаа явсан, хугацаа болоогүй-3 байна*/ явсан 76 бичиг байна. Мөн 1-2 сарын байдлаар сумын Засаг даргын “А” захирамж-21, “Б” захирамж-3 Тамгын газрын даргын “А” тушаал-3, “Б” тушаал-20 төлөвлөгдөж, баталгаажсан. Иргэдэд 15 лавлагааг гаргаж, бүртгэл хөтөлж ажилласан.
2. Төрийн албаны зөвлөлийн шинэчлэлтэй холбоотой Хүний нөөцийн удирдлагын нэгдсэн системд 56 албан хаагчийн ажил эрхлэлтийн түүх, шийдвэрийг оруулж, алдааг засаж ажилласан. Мөн төрийн албаны зөвлөлийн ХНУНС-ийн ашиглалттай холбоотой цуврал 13 хичээлийг үзэж судалсан.
3. Байгууллагын дотоод зөвөлгөөнийг 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулж 60 албан хаагчийг хамруулсан. Энэхүү зөвлөгөөний үеэр тасаг нэгжийн дарга, бодлогын мэргэжилтэн, байгууллагын дотоод зөвлөлүүд 2022 онд хийж хэрэгжүүлэх онцлог ажил, хамтран хийхээр төлөвлөсөн ажил, арга хэмжээнийхээ талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч, Илтгэх индрийн ирээдүй төрийн бус байгууллагын илтгэгч Д.Хүрэлбаатар “Сэтгэлгээний өөрчлөлт” сэдэвт сургалтыг орсон.
4. Харьяа төсөвт ЕБС-ийн 4 сургууль, СӨБ-ийн 11 цэцэрлэг, ОНӨААТҮ-ийн 3 газар, бодлогын мэргэжилтэн, багийн засаг дарга, засаг даргын зөвлөлийн гишүүд нийт 60 хүнийг хамруулсан удирдах ажилтны зөвөлгөөнийг зохион байгуулалтын үйл ажиллагааг хийсэн. Энэхүү зөвөлгөөний үеэр удирдлагын арга барил сэдэвт хувь хүний хөгжлийн сургалтад удирдлагуудыг хамруулж ажилласан.

5. Боловсрол өргөө дотуур байрны сурагчдад “Бид оюутны байранд юуг сурах ёстой вэ?” сэдэвт сургалтыг зохион байгуулж, 42 сурагчийг хамруулсан.
6. Байгууллагын хөдөлмөрийг гэрээг шинэчилж боловсруулсан.
7. Жижүүр, жолооч, үйлчлэгч нарын сарын ажлын тайлангийн маягтыг боловсруулж, Зохион байгуулалт үйлчилгээний тасгийн даргад тушаасан.
8. Цаг бүртгэлийн системд бүртгэлгүй байсан 8 албан хаагчийг бүртгэсэн.
9. Албан хаагчдын 2022 оны жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулсан.
10. Нээлттэй 1 ажлын байрны зарласан.
11. Төрийн албаны сүхбаатар аймаг дахь салбар зөвлөлд ажлын байрны сул орон тоог зарлуулахаар хүргүүлсэн.

ХОЁР: ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

1. Гүн өрмийн худгмийг 5 хэсэгт газарт гаргах талаарх судалгааг Баруун-Урт сумын 8 дугаар багийн ажлын албатай хамтран гаргаж, Аймгийн ХААГазарт хүргүүлсэн.
2. Үлийн цагаан оготны тархалтын судалгааг хийж 8000 га талбайд тархалттай байгаагаас 5000 га-д устгал хийх шаардлагатай байгааг олж тогтоосон.
3. Хүнсний дэлгүүрүүдэд “Тамхины хяналтын тухай хууль”, тогтоомжийн хэрэгжилтийн биелэлтийг хангах ажлын хүрээнд тамхины зөвшөөрөл хүссэн 6 аж ахуйн нэгжүүдэд хэмжилт хийж ажилласан. Уг ажлыг Цагдаагийн газар, Стандарт хэмжил зүйн хэлтэс, Аж ахуйн нэгжүүдийн захирал нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэгтэй хамтран хийж сургууль болон сурагчийн дотуур байрны ашигтай цэгээс аж ахуйн нэгжийн хаалга хүртэлх хэмжилтийг хийж, хуулийн дагуу хэмжилт хүрсэн 4 аж ахуйн нэгжид зөвшөөрөл олгосон.
4. Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн 2 аж ахуйн нэгжид зөвшөөрөл олгосон.
5. Ковид-19 цар тахалтай холбогдуулан сумын хэмжээнд томоохон үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдээс нөөцийн мэдээг 12 аж ахуйн нэгжээс 12 төрлөөр, махны мэдээг 6 аж ахуйн нэгжээс 5 төрлөөр, үнийн мэдээг 12 аж ахуйн нэгжээс авч нэгтгэн, 7 хоног бүрийн 1 дэх өдөр хугацаанд нь холбогдох газарт мэдээлэн ажилласан.

6. Аж үйлдвэрийн мэдээг сумын хувиараа үйлдвэрлэл эрхэлдэг иргэдээс хүнс, оёдол, модон эдлэл, блок зэрэг чиглэл, чиглэлээр сарын үйлдвэрлэлийн хэмжээг нэгтгэж Статистикийн хэлтэст мэдээлсэн.

ГУРАВ. ИРГЭДЭД ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ТҮРГЭН ШУУРХАЙ ҮЗҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

1. Аймгийн Засаг даргын 2022 оны А/733, сумын Засаг даргын А/04 тоот захирамжаар цэргийн тоо бүртгэл 01 дүгээр сарын 10-21 хооронд явагдлаа. Цэргийн нэгдсэн тоо бүртгэлийн мэдээ, тайланг захирамжийн хавсралтад заасан хугацаа буюу 02 сарын 28 өдөр тушаалаа. Бүртгэлийн хувь-72%
2. 13 хүсэлт, гомдол ирж шийдвэрлэсэн -5, холбогдох газарт уламжилсан-5, хугацаа болоогүй 3 өргөдөл байна.
3. 6, 8 дугаар багийн ажлын албанаас 2 иргэнийг түр болон байнгын ажлын байранд холбон зуучилж ажилласан байна.
4. Аймгийн Онцгой байдлын газрын “Аюулгүй галлагаа” аяны хүрээнд хамтран пийшин зуух, яндангийн аюулгүй байдлыг үнэлэх шалгуур үзүүлэлтийн үнэлгээг нийт 8 багийн 400 өрхөөр орж үнэлгээ хийсэн.
5. Тусламж дэсжлэг үзүүлсэн байдал:
 - 4-р багийн АИТХ-ын төлөөлөгч нарын санаачлагаар багийнхаа 50 ахмадад цагаан сарын гарын бэлэг өгч хүндэтгэл үзүүлсэн.
 - 4-р багийн сумын ИТХ-ын төлөөлөгч О.Батсайхан төрсөн өдрөөрөө багийнхаа нэг өдөр төрсөн 5 иргэнд гарын бэлэг өгч баяр хүргэсэн.
 - 6-р багийн ажлын алба Аймаг болон сумын ИТХ-ын төлөөлөгч нартай хамтран багийн 200 ахмадад Цагаан сарын хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулсан.
 - Багийн ажлын албууд уламжлалт сар шинийн баярын тохиолдуулан 90-с дээш насны 17 ахмадад Аймгийн засаг даргын гарын бэлгийг гардуулан хүндэтгэл үзүүллээ.
6. ГБХЗХГазрын “Гэр бүлийг дэмжих” туршилтийн хөтөлбөрийн хүрээнд 45 иргэнээс Гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ хийн, судалгаанд хамруулсан.

7.8-р багийн ажлын албанаас иргэдэд өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран коронавируст өвчнөөс урьдчилан сэргийлэх, вакцинжуулалтын мэдээ мэдээлэл олгох сургалт зохион байгуулж иргэдийн хамрагдалтыг нэмэгдүүлэх ажил зохион байгууллаа. Нийт 12 иргэн хамруулсан.

ДӨРӨВ. КОРОНАВИРУСТ ХАЛДВАР ЦАР ТАХЛЫН ХҮРЭЭНД ХИЙГДЭЖ БАЙГАА АЖИЛ АРГА ХЭМЖЭЭ

1. - Ковидын нэг цэгийн үйлчилгээгээр:

Ойрын хавьтал шинжилгээнд 6331үүнээс эерэг-3662,

Нийт батлагдсан-4745

Гэрийн эмчилгээнд-4114, АНЭ-631

-Тандалтын багаар

Батлагдсан тохиолдол-8806

Хяналтад байгаа ойрын хавьтал-124

2. Вакцины нэмэлт тунгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэн хамрагдаагүй иргэдийн судалгааг гарган нэрсийн жагсаалтыг баг тус бүрт хүргүүлэн хамрагдалтыг нэмэгдүүлэн ажиллаж байна. Мөн өрхийн эрүүл мэндийн төвүүд албан газар, Аж ахуй нэгж байгууллагаар явуулын дархлаажуулалтыг хийж өнөөдрийн байдлаар Баруун-Урт 3-р тун 8346-53% 4-р тун 1460 хамрагдалттай байна.

3. Аюултай хог хаягдлыг Сүхбаатар Хот тохижилт ОНӨГазартай холбогдон тогтмол ачуулах зэрэг ажлыг тус тус зохион байгуулан ажиллаж байна.

4. Ковид-19 нэг цэгийн үйлчилгээнд дэмжлэг болгон 200 ширхэг түрэгвчилсэн оношлуур өгсөн. Мөн ачаалал их хүний нөөц дутмаг байсан асуудлыг шийдвэрлэж, бүртгэлийн ажилтан нэмэлтээр ажиллуулсан.

5. АОК-ын 2022.01.18 өдрийн 01/03 албан даалгаварын хэрэгжилтийг ханган

Сумын Засаг даргын 2022 оны 01 сарын 19 ны өдөр А/15 тоот захирамжаар хяналтын баг томилогдож, багийн ажлын хэсгийн хурлыг зохион байгуулсан.

ТАВ: НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР

1. Монголын улаан загалмай .нийгэмлэг нь Катарын улаан хавирган сар нийгэмлэгтэй .хамтран “Дулаан өвөл” төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ хүрээнд тус сумын гамшгийн нөхцөлд байгаа 1 өрхийн судалгааг явуулж тусламжийн бараа олгосон.

2. Сумын Монгол хэлний бодлогын ажлын хэсгийг анхдугаар хуралдааныг хуралдуулж 2022 онд хийгдэх ажлын төлөвлөгөөг гарган батлуулсан.

3. Аймгийн Соёл урлагийн газраас ирүүлсэн “Бүх нийтийн боловсрол”-ын өнөөгийн түвшин буюу суурь нөхцөл байдал иргэдийн соёлын боловсролын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох дүн шинжилгээ хийх судалгааг 18-24, 25-34, 35-44, 45-54, 55-64, 65-аас дээш насны 36 иргэнээс маягтын дагуу судалгааг авч нэгтгэлийг хийж хугацаанд нь хүргүүлсэн.

ЗУРГАА: ХОТ ТОХИЖИЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖ, ДЭД БҮТЦИЙН ЧИГЛЭЛЭЭР

Долоон уулзварын гэрлэн тохио болон нийтийн эзэмшлийн талбайд байгаа камеруудыг хүлээн авах ажлыг уртын гэгээ ОНӨААТҮГазартай хамтран зохион байгуулсан.

Сумын танилцуулгад оруулахаар тухайн нутаг дэвсгэрт байгаа хөшөө дурсгалыг зурагжуулсан.

Замын цагдаагийн тасгийн журмын хашааны жижүүрийн хөдөлмөрийн хэрээг сунгаж ажиллаа.

Сумын 2022 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан дуудлага худалдаа зохион байгуулах газруудын төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна.

Спорт хамтлагийн төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна.

Таван эрдэнэ хороололын айл өрхүүдийн хүсэлтийн дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээний материалыг бүрдүүлэн Сүхбаатар сумын ИТХ-д хүргүүлэн гэрчилгээжүүлэх ажлыг хийж гүйцэтгэж байна.

Эко хороололын төлбөр тооцоогоо бүрэн барагдуулсан иргэдийн газар өмчлөх эрхийн баримт бичгийг бүрдүүлэн ГХБХБГ-т албан хүсэлт хүргүүлэн ажиллаж байна.

ГХБХГ-аас ирүүлсэн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн хэрэглээг эрчимжүүлэх ажлыг хийж гүйцэтгэж байна.

Хотын төвөөс мал гаргах ажлын хүрээнд Сүхбааатар тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-тай хамтран мал бүхий иргэдэд мэдэгдэл хүргүүлж мөн хашиж журмалах ажлыг зохион байгууллаж байна.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ЧИГЛЭЛЭЭР

2022 оны 01 сарын 25-ны өдрөөс 02 сарын 18-ны өдрүүдэд нийт 399 ширхэг гүйлгээний 787,539,194.5 төгрөгийн дүнтэй төсөвт байгууллагын гүйлгээг хийж батлуулсан байна.

02-р сарын баримтыг хуулгатай тулган архив нэгж үүсгэхэд бэлэн болгосон.

Санхүүгийн албаны групп дээр тавьсан мэдээлэлүүдийг цаг тухай бүрд нь төсөвт байгууллагын нягтлан бодогч, захирал , эрхлэгч нар өөрсдийн дотоод группээр дамжуулан хүргэж байна.

2022 оны 02 сараас эхлэн төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны данс шинээр нээгдсэнтэй холбоотойгоор дансны гарын үсгийн баталгааг шинээр 18 байгууллагадаа авч эрхийн бүртгэлийн санд оруулсан.

Цагдаагийн газрын журмын хашааны 02 сарын төлбөрийн баримтыг хуулгатай тулган хүлээн авч баталгаажуулсан.

Тайлангийн нэгтгэл хийсэн: Хүний нөөцийн Ажилтан Б.Болортуул

Тайлантай танилцсан

Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Сарангэрэл

2022.02.23